

Дундговь аймгийн Өлзийт сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 онд хийсэн ажлын тайлан

2014-11-30

Рашаант

Нэг. ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бодлого боловсруулах талаар хийсэн ажил

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын суманд холбогдолтой 5 тогтоолын 9 заалтыг хяналтанд авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулснаар 7 заалт бүрэн хэрэгжиж, 2 заалт дутуу биелэлттэй байна. Сумын ИТХ-аас 35 заалт бүхий 13 тогтоол гаргасан байна. Тогтоолыг агуулгаар нь ангилж үзвэл Төсөв хөрөнгө баталж тодотгосон 6, газрыг тусгай хамгаалалтанд авсан 2, сумын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх журам 2, Газрын төлбөр, хураамж тогтоосон 2, сумын ерөнхий төлөвлөгөө, дэд бүтэцтэй холбоотой 1 тогтоолыг гаргасан байна. Эдгээр тогтоолоос хяналтанд авч хэрэгжилтийг тооцож байх 14 заалтын хэрэгжилтийг тооцож үзвэл Засаг даргад даалгасан 12, ажил хариуцсан түшмэлүүдэд үүрэг болгосон 2 заалт байна. Эдгээр 14 заалтаас бүрэн хэрэгжсэн 11 заалт, дутуу хэрэгжсэн 2, хэрэгжих болоогүй 1 заалт байна. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосны хураамж, газрын төлбөрийн хураамж дутуу биелэлттэй байна. Сумын тахилгатай уул тахих заалт хугацаа болоогүй байна.

2014 онд ИТХ-аар орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх, сумын төвийг хөгжүүлэх, газар нутгаа хамгаалах, иргэдийн оролцоог хангах чиглэлээр бодлого боловсруулан батлаж хэрэгжүүллээ. Тухайлбал: Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны хураамжийн хэмжээг нэмэгдүүлсэн, газрын төлбөрийг ангилан ялгаж ялгавартай тогтоосон, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, дэд бүтцийн шугам сүлжээний байршлын зураглалыг баталсан, Зарим уулыг сумын тахилгатай болгосон, сумын нийгэм, эдийн засгийн 2009-2020 оны төлөвлөгөөнд үнэлгээ хийж шинэчилсэн, сумын бодлого, төлөвлөлт, хяналтын зөвлөлийг шинэчлэн баталсан зэрэг нь сумаа хөгжүүлэх, ОНХС, СХС, ХЭДС-ийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад ач холбогдолтой боллоо гэж үзэж байна.

Энэ онд удирдлагын шийдвэрт иргэдийн оролцоог идэвхжүүлэх, иргэний нийгмийн байгууллагуудын санал хүсэлтийг шийдвэрлэх, хамтарч ажиллахад анхаарч ажиллалаа. Иргэдэд түүний сонгосон төлөөлөгчид ямар эрхтэй, асуудлыг яаж шийддэг, ОНХС-ийн хөрөнгийн талаар иргэдээс ирсэн саналыг ИТХ дээр хэрхэн хэлэлцэж шийдвэрлэдэг болохыг харуулах зорилгоор 6 багийн нэгдсэн өдөрлөгийн үеэр ИТХ-ыг нээлттэй хийж 2015 оны ОНХС-аар хийгдэх ажлын эрэмбэлсэн жагсаалт, газрын үнэлгээний ангилал, төлбөрийн хэмжээг тогтоох, зарим уулыг сумын тахилгатай болгох тухай асуудлыг хэлэлцэж баталсан. Нээлттэй хуралд 6 багийн иргэд, Аймгийн засаг дарга, “Мерси кор” ОУБ-ын аймаг

дахь төлөөлөгч, аймаг дахь “Монцаме” агентлагийн сурвалжлагч, дэд бүтцийн ажил хийж буй “Санжат” ХХК-ны удирдлагууд оролцож мэдээлэл хийсэн. Иргэд өөрсдийн өгсөн саналаа хэрхэн эрэмблэгдэж эцсийн шатандаа яаж шийдвэрлэгддэг болохыг харж саналаа хэлсэн.




ИТХ-ын 10-р хуралдааныг иргэдэд нээлттэй хийж байгаа нь..

Суманд ОНХС-ийн хөрөнгө буй болсонтой холбогдуулан иргэдээс ирсэн саналыг орон нутгийн бодлоготой уялдуулах, ОНХС, Сум хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэх сангийн үйл ажиллагааг давхардуулалгүй зөв зохистой ,харилцан уялдаатай явуулах, 2009 онд батлагдсан сумын “нийгэм, эдийн засгийн 2009-2020 оны хөгжлийн төлөвлөгөө”-нд үнэлгээ хийж шинэчлэн боловсруулах ажлыг иргэд, ТББ, мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор хийж гүйцэтгэлээ. Үүний тулд дараахь ажлыг хийв.Үүнд:

1. Багийн засаг дарга нарыг бүх айл өрхөөр явуулж сумын нийгэм, эдийн засгийг 2014-2025 онд хөгжүүлэх төлөвлөгөөнд тусгай асуултаар давхардсан тоогоор 300 санал авч нэгтгэж эрэмбэлсэн
2. Сумын төвийн иргэдийн төлөөлөл, төрийн албан хаагчдийн оролцоотойгоор “Мерси Кор” ОУБ-тай хамтран орчин үеийн судалгааны “расед” аргаар ойрын хугацаанд болон ирээдүйд хөрөнгө оруулалт хийх ажил, үйлчилгээг эрэмбэлж гаргасан
3. Сумын ОНХС, СХС, ХЭДС-ийн улдаа холбоог хангах, сумын хөгжлийн мастер төлөвлөгөөнд үнэлгээ хийх, нэмэлт өөрчлөлт оруулах, хяналт тавих үүрэг бүхий бодлого, төлөвлөлт, хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг боловсруулж Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн ИТХ-д оруулж байна.



Сумын нийгэм, эдийн засгийн 2014-2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд оруулах төслүүдийг эрэмбэлж байгаа нь



Сумын бодлого, төлөвлөлт, хяналтын зөвлөлийн чиг үүргийн бүтэц, сангуудын уялдаа, холбооны бүтцийн схем гаргаж байгаа нь

Сумын 1, 2-р багаас сонгогдсон төлөөлөгчид сум хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд буянт багийн хөгжлийн талаар оруулах саналаа албан ёсоор ирүүлсэн. Сумаас аймагтай хамтарч гаргасан ерөнхий төлөвлөгөөнд уг саналыг оруулж батлуулсан боловч яамны түвшинд зөвхөн сумын төвд хамааралтай гэдгээр хасагдсан. Гэвч ИТХ-ын дарга, Засаг дарга “Жи-Мобайль”, “Юнител”ХХК-иудад удаа дараа хүсэлт тавьж 108 сая төгрөгний өртөгтэй “Жи-мобайл”-ийн сүлжээ Буянт багт тавигдахаар гэрээ байгуулагдаад байна. Төлөөлөгч Б.Насан болон 1-р багийн ИНХ-аас ирүүлсэн саналын дагуу “Талын богд” уулыг сумын

тахилгатай болголоо. “Өөшийн өгөөж”ТББ-ын ирүүлсэн хүсэлтийн дагуу 2013 онд гаргасан газар эзэмшүүлэх тухай 1 захирамжийг иргэдийн нийтлэг эрх ашгийн төлөө хүчингүй болгож 4 га газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд бичил уурхай эрхлэх зариулалтаар авч АМГ-ын кадастарын хэлтэст бүртгүүлэн дүгнэлт гаргуулсан. Энэ нь хуульд заагаагүй асуудлаар Үндсэн хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж орон нутгийн эрх ашгийг хамгаалсан, иргэдийн хүсэлд нийцсэн бие дааж гаргасан шийдвэр байлаа. Сумын ахмадын холбоо, Залуучуудын холбоо, Эрэгтэйчүүдийн холбоо, “Мерси Кор” ОУБ, “Хил хязгааргүй алхам”ТББ , “Нутгийн удирдлагын холбоо” Аймгийн “Улаан загалмай нийгэмлэг “зэрэг иргэний нийгмийн байгууллагуудтай төсөл боловсруулах, хэлэлцүүлэг хийх, сургалт явуулах чиглэлээр хамтран ажиллав. Дээр нэр дурьдагдсан төлөөлөгчид, ТББ-ын адилаар ИТХ-аараа сонгогчдийнхоо нийтлэг эрх ашгийн асуудлыг шийдүүлж байхыг төлөөлөгчдөд уриалж байна. Иргэдийн хуралтайгаа хамтарч ажилласан төлөөлөгчид, ТББ-дад Тэргүүлэгчдийн өмнөөс талархал илэрхийлж байна.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид 2014 онд 12 удаа хуралдаж 28 заалт бүхий 26 тогтоол гаргасан байна. Тогоолыг агуулгаар нь ангилвал журам 4, хурлын тов 5, шагнал 6, зөвлөл, ажлын хэсэг, комисс байгуулах 8, Газар, ашигт малтмалын талаар 2 тогтоол гаргасан байна. Хяналтанд авч биелэлтийг гаргаж байх 6 тогтоолын 13 заалтын биелэлтийг гаргахад 85 хувийн биелэлттэй байна. Тэргүүлэгчид нийтээр дагаж мөрдөх 8 журам гаргаж баталснаас хог хаягдлын болон СХС-ийн зээлийн журмын хэрэгжилт хангалтгүй байна.



Сумын сүлд, тугийг шинэчлэн батлав.

Хоёр. Хяналт, шалгалт, дотоод ажлын талаар

Сумын ИТХ-ын дэргэдэх 4 ажлын хороогоор чиг үүргийнх нь хүрээнд батлагдсан удирдамж, хуваарийн дагуу төсвийн байгууллагууд, ААН-үүдэд дотоод хяналт, шалгалтыг сарын хугацаанд хийлгэж шалгалтын тайланг гаргуулан үр дүнг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэв. Тэргүүлэгчдийн хуралдаанаас Засаг дарга, албан байгууллага, ААН-ийн захирал, эрхлэгч нарт албан шаардлага, зөвлөмж,

хугацаатай үүрэг даалгавар өглөө. Дотоод хяналт, шалгалтын нэгдсэн дүнг мэдээлэлийн цагаар нийтэд мэдээлж, малын тоогоор нийт малчин өрхөд хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Дотоод хяналт шалгалтыг байгууллагуудын өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, иргэдийн өргөдөл, гомдлын бүртгэл түүнийг шийдвэрлэсэн байдал, ИТХ-аас гарсан тогтоол, шийдвэрийн биелэлт, хэрэгжилт, ахмад, залуучууд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон амжиргааны түвшин доогуур иргэдийн талаар гарсан төсөл, хөдөлбөрүүдийн хэрэгжилт, ОНХС, СХС, ХЭДС-ийн зарцуулалт, Ашигт малтмал олборлогч ААН-үүдийн үйл ажиллагаа, хандив, тусламж, төлбөр төлөлтийн байдал, түгээмэл тархацтай ашигт малтмалын хураамжийн орлогын төвлөрүүлэлт зэрэгт чиглүүлсэн. Шалгалтын үр дүнд нэг талаас иргэдийн төлөөлөгчид сумын нийгэм, эдийн засгийн одоогийн бодит байдалтай газар дээр нь танилцаж, нөгөө талаас төрийн байгууллагууд өөрийн алдаа дутагдлыг мэдэж, сайн талаа төлөөлөгчдөд танилцуулсан байна. Үүний үр дүнд ирэх онд ИТХ, Засаг даргаас авах арга хэмжээ, байгууллагууд өөрсдөө зохион байгуулж хэрэгжүүлэх ажлыг тодорхой болгосон. Шалгалтын үр дүн нь төрийн бүх үйлчилгээг иргэдэд нээлттэй байлгахад чухал ач холбогдолтой боллоо гэж тэргүүлэгчид дүгнэлээ.



ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар Ажлын хороодын дотоод хяналт, шалгалтын тайланг хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөв.

ИТХ-ын 2014 онд хийх ажлын төлөвлөгөөнд 39 асуудал төлөвлөснөөс 1 ажил хугацаа болоогүй/хом/, 1 асуудал дутуу биелэсэн/БИНХ-ын дарга, Төлөөлөгчдийн ажиллах журам/, 1 ажил биелээгүй/Өмчийн бодлого боловсруулах-аймгаас журам гарсан/ байна. Ажлын албанаас улирал бүр төлөвлөгөө гарган ажилласан. ИТХ-ын Тэргүүлэгчдээр “Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн ажиллах журам”, “Сумын БИНХ-ын даргын ажил дүгнэх журам”-ыг батлан гаргасан. Журмын дагуу БИНХ-ын дарга нарын ажыг дүгнэж урамшуулал олгож байна. Ихэнх хурлын дарга нар БИНХ-ын

үед ажиллахаас бусад үед иргэдтэйгээ ажиллахгүй санаачлага гаргахгүй байна. Ажлын алба эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтаа сайжруулахын зэрэгцээ 2.2 сая төгрөгний засварыг ажлын байранд хийж ажиллах нөхцөл бололцоог сайжруулсан. Бичиг хэрэг, архивын ажлыг стандартын дагуу хийж төрөлжүүлсэн. Ажлын албанд 32 бичиг ирж хариутай 20 бичгийн хариуг өгсөн ба 25 бичиг явуулсан байна. 21 төлөөлөгч, 3 багийн засаг даргын хөрөнгө орлогын мэдүүлгийг авч АТГ-т хүргүүлсэн. Ажлын албанд 15 өргөдөл, санал ирсэнийг 100 хувь шийдвэрлүүлсэн. Өргөдлийн 60 хувь нь шагнал, эхийн одон байв.

Гурав. Сургалт, сурталчилгааны ажлын талаар

Монгол улсын хууль, Аймаг сумын ИТХ-аас гарсан тогтоол, шийдвэрийг БИНХ, мэдээлэлийн цагаар иргэдэд яриа, таниулга хэлбэрээр хийсэн. Төрийн мэдээлэл сэтгүүлийг захиалж иргэний танхимаар үйлчилсэн ба 21 төлөөлөгчид 4-р улиралд аймгийн сонинг захиалсан. ИТХ, Тэргүүлэгчдээс гарсан шийдвэр, цаг үеийн ажлыг мэдээллийн самбараар ил тод тогтмол мэдээлж, сумын сонин, вэб сайдад зарим мэдээг тавьсан. ИТХ-ын тэргүүлэгчид, ажлын албанаас 2014 онд хийсэн шинэлэг ажлыг гаргаж аймгийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлж сурталчлуулсан. Аймагт болсон НӨУЁБ-ыг чадавхжуулах сургалтанд сумын төлөөлөгчдийг хамруулсан. Мөн эмэгтэй төлөөлөгчид аймагт сургалтанд, нарийн бичгийн дарга нутгийн удирдлагын холбоонооны, АТГ-ын хом бүртгэх, хянах тухай сургалтанд хамрагдсан байна. Суманд болсон хүний эрхийн тухай сургалтанд 7 төлөөлөгч, 1 БИНХ-ын дарга оролцсон. Шинэ үндсэн хууль батлагдсаны 22 жилийн ойгоор төрийн далбаа залах ёслол үйлдэж, ЕБС-ийн сурагчид иргэний андгай өргөж, ахмад төлөөлөгч Н.Цэвэгмэд дурсамжаа ярилаа. Энэ үеэр хүүхэд, насанд хүрэгчдийн дунд шатрын тэмцээн, нийт иргэдийн дунд үндсэн хуулиар “Центавр” тэмцээн зохион явууллаа.



Үндсэн хууль батлагдсаны 22 жилийн ойн арга хэмжээ

Сумын ЗДТГ-тай хамтран “Хууль дүрэм бодит амьдралд” аяны хүрээнд Үндсэн хууль, Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг сурталчилах зорилгоор иргэд, албан байгууллагуудын дунд “Элсэн цаг” тэмцээнийг зохион явууллаа.



“Элсэн цаг” тэмцээнд тэргүүн байр эзэлсэн багууд

Дөрөв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар

1.Өлзийт сумын ГХУССЗөвлөл нь зөвлөлийн дарга, сумын ИТХ-ын дарга Х.Отгонмөнх, нарийн бичгийн дарга, хэсгийн төлөөлөгч Л.Ёндон /өнмө хэсгийн төлөөлөгчөөр ажиллаж байсан Б.Билгүүн/, гишүүд: Засаг дарга И.Эрдэнэбилэг, Сургуулийн нийгмийн ажилтан Б.Жавзмаа, Нийгмийн бодлогын ажилтан Б.Оюунханд, 1-р багийн Засаг дарга Б.Мөнхцэцэг, 2-р багийн Засаг дарга П.Алтанцэцэг, 3-р багийн Засаг дарга Д.Наваантаяа, 4-р багийн Засаг дарга Г.Бархас, 5-р багийн Засаг дарга О.Ган, 6-р багийн Засаг дарга Ө.Буд-Очир нарын бүрэлдэхүүнтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж болон хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ажлаа жил, улирлаар төлөвлөн ажиллаж байна.

Суманд хийгдэж буй дэд бүтцийн ажилтай уялдуулан учирч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх **“Хэрэг зөрчлийн эсрэг хамтдаа”** 3 сарын аяныг 2014 оны 11-р сарын 24нөөс эхлэн зохион байгуулж, аяны хүрээнд **“хариуцлагатай жижүүр”**-ийг тогтмол 7/24 цагаар ажиллуулж үр дүнг тооцож байна. Мөн аяны хүрээнд **“Архигүй Дундговь”** хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллага, иргэдийн дунд архины эрсэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна.

2. Малын хулгайн болон тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах чиглэлээр

2014.03.04-05-ны хооронд зохион явагдсан багуудын нийтийн хурал, өдөрлөгүүдэд ГХУССЗ-өөс “Малын болон хулгайн гэмт хэргийн эсрэг хамтдаа” сэдвийн дор малын хулгайн гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, илрүүлэхийн тулд ГХУССЗ, малчид иргэдийн хамтын ажиллагааны ач холбогдол зэргээр сургалт, харилцан яриа таниулга хийж, санал солилцсон.

Цагдаагийн хэсгээс жил бүр зохион явуулдаг “Сар шинэ нэгдсэн арга хэмжээний хүрээнд малчид болон мал бүхий иргэдэд өөрсдийн малыг байнгын хариулгатай байлгах, гэр орон сууцны хаалга цоожны бүрэн бүтэн байдлыг хангаж, гэр сууцаа байнгын эзэнтэй байлгах талаар сэрэмжлүүлэг тарааж мөн байгууллага аж ахуйн нэгжүүдэд тухайн объектын харуул хамгаалалтыг сайжруулах өдрүүдэд гарах хариуцлагатай эргүүл жижүүрийн ажилд байнгын хяналт тавих, тэдгээрийн хэвийн үйл ажиллгааг хангуулах талаардарга эрхлэгч нарт нь мэдэгдэл хүргүүлж биелэлтийг хугацаанд нь тооцож авхуулж байна.

Сумын төвөөр сүүлийн үед нилээд ихэсч байгаа иргэдийн мал руу дайран хохирол учруулж буй золбин гэх ноход болон эзэнтэй ноходод чиглэсэн тодорхой

арга хэмжээ авах талаар 6-р багийн Засаг дарга Ө.Буд-Очирт мэдэгдэл хүргүүлсэн ба мэдэглийн дагуу тодорхой ажил хийгдэж байна. Мөн сумын төв буюу Наадмын талбайн арын гэрлийн шонгийн тогтой утас доош унжин доогуур нь гарсан мотоцикльтой болон автомашинтай хүмүүсийн эрүүл мэнд, амь нас хохирохоос урьдчилан сэргийлэн сумын Эрчим хүчний монтер Дэндэвт дээрхи эрсдлийг арилгуулах талаар мэдэгдэл хүргүүлэн унжсан утсыг дээш татаж хэвийн болгосон.

ГХУССЗ-өөс зохион байгуулж буй “Хэрэг зөрчлийн эсрэг хамтдаа” аяныг хэрэгжүүлж ажиллах уриалга, санамж бичгийг малчид, иргэд бүхий 300 өрхөд тараахаар бэлтгэж сумын мал тооллогын комиссын гишүүдэд өгөөд байна.

3. Согтуугаар үйлдэгдэж буй болон ахуйн хүрээний гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах чиглэлээр

Архидан согтуурч амьдарч буй орчиндоо таагүй уур амьсгал бүрдүүлдэг болон өмнө нь ахуйн хүрээний танхайн гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан болон шалгагдаж байсан иргэдийн судалгааг Цагдаагийн хэсгээс гарган дээрхи 15 иргэнийг хамруулсан сургалтыг “Сайхан гэр бүл бидний ирээдүй” сэдвийн дор 2014.01.25-нд сумын ГХУССЗ, Цагдаагийн хэсэг, Эрчүүдийн холбоо, Эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран зохион байгуулсан. Мөн 2014.03-18-нд “**Архи уух 13 шалтаг**” сэдвийн дор 36 эрчүүдийг хамруулсан сургалтыг сумын Эрчүүдийн холбооноос зохион явуулсан. Согтуугаар үйлдэгдсэн /жигжээр танхайрах/ зөрчлийн улмаас хохирсон 3 гэрийн эзэгтэйн сэтгэл санааг дэмжих, тэдэнд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх /гоо сайхны хэрэгсэлээр/ ажлыг эмэгтэйчүүдийн холбоо, сумын улаан загалмайн ажилтантай хамтран зохион байгуулж ажилласан. Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, хэсгийн цагдаагийн зүгээс өдөр тутам гудамж талбайд эргүүлийн үүрэг гүйцэтгэж хууль тогтоомжийн биелэлтийг хангуулж ажиллаж байгаа нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг үндэс нь болж байна.

4. Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах чиглэлээр

Өлзийт сумын хэмжээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Мөнхийн жонш ХХК, Адил-Оч ХХК гэх зэрэг аж ахуйн нэгжүүдийн удирлагуудтай нэг бүрчлэн уулзаж үйл ажиллагаа явуулахдаа холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу ажиллах, бэлчээр, ан амьтанд хохирол учруулахаар хориотой үйл ажиллагаа явуулахгүй байх талаар ярилцан бичгээр баталгаа гаргуулан авч байна. Уурхайн ажлын явцад хүний эрүүл мэнд, амь нас хохирохоос сэргийлэн уурхайн хэмжээнд ашиглагдаж байгаа тэсэрч дэлбэрэх бодисын хадгалалт, хамгаалалт болон тээврийн хэрэгслүүдэд хийх үзлэг шалгалтыг 2 удаа

явуулсан мөн уурхайн бусад үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэхэд байгаль орчны байцаагч, татварын байцаагч нартай хамтран хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах талаар мэдэгдэл хүргүүлэн биелэлтийг хугацаанд нь тооцож авсан болно.

Байгаль хамгаалагч Б.Бадрахтай хамтран Өлзийт сумын 3-р багийн нутаг дэвсгэр Зүүн Даянгарын тус газраар гар аргаар хууль бусаар алт олборлож буй иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлээр 2 удаагийн эргүүлийг зохион байгуулсан, мөн аргаль, янгир, зээр зэрэг хориотой ан агнуур хийгдэж байгаа эсэхийг тогтоох, илэрсэн зөрчилд хуулийн дагуу арга хэмжээ авах зорилгоор 1 удаагийн эргүүлийг байгаль орчны байцаагч, хэсгийн төлөөлөгч нар хамтран зохион байгуулсан.

Мөн тус багийн нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаад эргэн нөхөн сэргээлт хийгдээгүй Арслан хад, Цагаан дэвсэг, Хүрэн дэл, Хөтөл, Гурван ухаа гэх зэрэг газруудын судалгааг гарган холбогдох байгууллагад шилжүүлээд байна.

2014 оны 10-р сард ИТХ-ын ХАА, Байгаль орчин, Гамшгийн асуудал эрхэлсэн ажлын хорооноос сумын нутаг дэвсгэрт ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН болон жоншны бичил уурхайн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж үр дүнг тооцлоо.

5. Замын хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах чиглэлээр

2014.04.14-15-ны хооронд аймгийн Авто тээврийн газраас мэргэжилтнүүд Өлзийт суманд ирж сумын тээврийн хэрэгслүүдийг үзлэг оншилгоонд хамруулсан ба нийт сумын хэмжээнд 272автомашин, 76 мотоцикль хамрагдсан байна.

2014.02.04-ний өдөр сургуулийн 10-15 насны 3 ангийн 54 хүүхдийг оролцуулсан “Ногоон гэрэл-Цагаан шугам” сэдвийн дор замын хөдөлгөөний чиглэлээр сургалтыг сургуулийн удирдагуудтай хамтран зохион явуулсан байна.

Сумын төвийн замуудад байрлуулах замын тэмдэг тэмдэглэгээний тооцоог хэсгийн төлөөлөгчөөр гаргуулан сумын Засаг дарга И.Эрдэнэбилэгт сумын төвийн замыг тэмдэглэгээтэй болгох асуудлыг шийдвэрлүүлэхээр өгөөд байна.

Сар шинэ нэгдсэн арга хэмжээг Цагдаагийн хэсгээс зохион явуулж, сар шинийн баярын өдрүүдээр байгууллагууд Цагдаагрийн хэсэгтэй хамтарсан эргүүлд ажиллаж хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулж байлаа.

6. Насанд хүрээгүй хүмүүсээс гэмт хэрэг зөрчилд холбогдох, түүнд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах чиглэлээр

Өсвөрийн Цагдаа бүлэгтэй хамтран ажиллах төлөвлөгөөг Цагдаагийн хэсэг гарган сумын Засаг даргаар батлуулан, уг бүлэг нь одоогоор 9 хүүхэдтэй, чиглүүлэгч багш Ц.Наранбаатарын хамтаар Цагдаагийн хэсэгтэй хамтран үйл ажиллагаа явуулж байна. Сумын Дотуур байрны үйл ажиллагаа болон түүний бүртгэл судалгаа, байрны багш болон жижүүрүүдийн үүрэг гүйцэтгэлийн байдалд байнгын хяналт тавиулан ажиллаж байна. 2014.03.25-нд “**Дотуур байр миний гэр**” сэдэвт дотуур байрны хүүхдүүдийн дунд хууль эрхийн сургалт, танин мэдэхүйн тэмцээн уралдааныг Цагдаагийн хэсэг, Нийгмийн бодлогын ажилтан, Улаан загалмайн ажилтантай хамтран зохион явуулсан ба мөн дотуур байранд хүүхдийн эрх зөрчигдөж байгаа эсэх талаар санал асуулга авсан байна. Одоогоор Өлзийт суманд Насанд хүрээгүй хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн, түүнд өртсөн асуудал бүртгэгдээгүй байна. ы

7. Архидан согтуурахтай тэмцэх ажлыг сайжруулах чиглэлээр

Аймгийн Засаг даргаас “**Архигүй Дундговь**” Дундговь хөтөлбөрийн хүрээнд гаргасан А/03 тоот захирамжийн биелэлтийг хангах хүрээнд төрийн байгууллагын ажилтан албан тушаалтнуудын дунд ажлын байранд болон ажлын цагаар архидан согтуурах асуудалд хяналт тавин нийт байгууллагуудад Цагдаагийн хэсэг, ГХУССЗ-өөс архинаас татгалзах талаар уриалга гарган ажиллаж байна.

Сумын согтууруулах ундаа худалдан борлуудаг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Цагдаагийн хэсгийн зүгээс тогтмол хяналт тавьж нийтийг хамарсан үйл ажиллагаа суманд зохион явагдахад согтууруулах ундааг худалдахгүй байх талаар Засаг даргаар захирамж гаргуулан түүнд хяналт тавиулан ажиллаж байгаа бөгөөд мөн баяр ёслолоо архигүй сүү өргөн тэмдэглэх талаар уриалга, зөвлөмж тараан ажиллаж байна.

Зохион байгуулж буй аяны хүрээнд АИТХ-ын 2013 оны 92-р тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор бүх байгууллага ААН-үүдийн дунд “Архигүй орчин бүрдүүлэх” хөдөлгөөн өрнүүлэх болон архины эсрэг сургалт, сурталчилгаа зохион байгуулах ажлыг төлөвлөн хийж байна.

Тав.Дүгнэлт

2014 онд ИТХ-ын тэргүүлэгчид, ажлын албанаас дотоод хяналт- шалгалт хийх, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх, ашигт малтмал ашиглаж иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, иргэдийн оролцоог идэвхжүүлэх тал дээр бие даасан шийдвэр , шаардлагатай журмууд гаргаж эрх зүйн орчин бүрдүүлэхэд ажлын ахиц гаргаж ажилласан гэж үзэж байна. Гэвч иргэдэд мэдээлэл хүргэх, төлөөлөгчдийг тойрогт нь ажиллуулах, БИНХ-ын дарга нарыг чадавхжуулах тал дээр хангалтгүй ажилласан байна.

Цаашид тавих зорилт:

1. Иргэдэд мэдээлэл хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангахад шинэ арга барилаар ажиллах
2. Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч ажиллан тодорхой үр дүнд хүрэх зорилт тавин ажиллана.

Тайлан бичсэн: ИТХ-ын ажлын алба

